



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/15

Есөнбулаг

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн "Аймгийн 2024 оны төсөв батлах тухай" 71 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 40,000,000 (дөчин сая) төгрөгийн эх үүсвэрээр санхүүжигдэх Шарга сумын "Хамтын хүч" багт үүрэн холбооны сүлжээ суурилуулах ажлыг гүйцэтгүүлэх эрхийг Шарга сумын Засаг дарга (А.Алтангэрэл)-д шилжүүлсүгэй.

2.Төсөл арга хэмжээний ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг 2024 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор боловсруулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль журмын дагуу зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнахыг Шарга сумын Засаг дарга (А.Алтангэрэл)-д үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2023 оны 05 дугаар сарын А/304 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ

C:\Documents\ ZDA4

8230010205

